

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026.04.24

Улаанбаатар хот

Тус компанийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурал , хурал хийхээр товлосон зарын дагуу 2026.4.2-ны өдрийн 14 цагт бүртгэл эхэлж, 15 цаг 30 минутад Компанийн хурлын танхимд болов.

Хурлын дэгийн дагуу хурал эхлэхээс өмнө Тооллогын Комисс Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, саналын эрхийн тоо, хурлын ирц, Тооллогын Комиссын 2026.04.24 ны өдрийн “ Хүчин төгөлдөрт тооцох тухай” №01 тоот тогтоолыг тооллогын комиссын дарга Б.Хонгорзул уншиж танилцуулав. / Уг тогтоолыг хурлын материалд хавсаргав./

Тооллогын Комиссын дарга Б.Хонгорзул : Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд ширхэг хувьцаа эзэмшсэн 3.800.721 хувьцаа Эзэмшигчдээс саналын эрх бүхий 9982 ширхэг хувьцаа эзэмшсэн 19 хувьцаа эзэмшигч ирсэн байна. Энэ нь нийт хувьцааны 80,8 % -ыг төлөөлж байна. Иймээс Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 1-д заасан заалтыг үндэслэн “Хурал хүчин төгөлдөрт тооцсугай” гэв.

Үүний дараа хурал даргалагч байраа эзлээд хурлын дэг , Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор томилогдсон хурлын тэргүүлэгчид, нарийн бичгийн дарга болон тооллогын комиссыг танилцуулж ажилдаа орохыг урив.

Хурал даргалагч Өнөөдрийн хурлаар:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах
 2. 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах
 4. Ногдол ашгийг нэгж хувьцаанд 100 төгрөгөөр хуваарилах асуудлуудыг хэлэлцэнэ гэсний дагуу хурлын дараалал ёсоор :
-
1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн 2026 оны бизнесийн үйл ажилагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал Г.Бүдрагчаа илтгэв.
 2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг компанийн ерөнхий нягтлан бодогч С.Мөнхжаргал тайлагнав.
 3. ТУЗ-ийн 2026 оны төсөв болон. ТУЗ-д нэрдэвшигчдийн намтрыг уншиж танилцуулав.
 4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Ногдол ашиг хуваарилах” тухай тогтоолыг танилцуулав. Үүний дараа хувьцаа эзэмшигчдийн асуултанд хариулав.

Асуулт 1 Хувьцааны ноогдол ашиг энэ жил хэдэн төгрөгөөр тооцож олгох вэ?

- ✓ Өнгөрсөн оны ноогдол ашиг хэзээ өгч дуусах вэ?
- ✓ 2025 оны ноогдол ашиг хэзээнээс өгөх вэ?
- ✓ Ноогдол ашиг цаашид өсөх үү?
- ✓ Нийт хэдэн хувьцаа эзэмшигч байна вэ?

Хариулт: - 2025 оны ноогдол ашгийг 100 төгрөгөөр тооцон олгохоор ТУЗ-ийн тогтоол гарсан байгаа. 2022 оноос хойших хувьцааны ноогдол ашгийг ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан тараалгаж байгаа болно. 2025 оны ноогдол ашгийг бид 2026 оны 4 сарын 30-ны дотор ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан олгож эхэлнэ. Манай компанийн хувьд МИК-80 төслийг 3 үе шаттай хэрэгжүүлж байгааг та бүхэн мэдэж байгаа. Төсөл 2027 онд бүрэн хэрэгжиж дуусах бөгөөд 2030 оноос эхлэн үе шаттайгаар хувьцааны ноогдол ашгийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Манай компани 10.000 гаруй бөгөөд энэ жилийн тархалтын судалгаагаар 9.982 хувьцаа эзэмшигчтэй байна.

Асуулт 2 Сүүлийн жилүүдэд их хэмжээний хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж байна. Энэ тал дээр ашиг алдагдлын тооцоо байна уу? Хөрөнгө оруулалтыг хэдийд нөхөж дуусгах тооцоо байна уу?

Хариулт: - 2019 оноос эхэлсэн үйлдвэр болон зоорь, мал төхөөрөх үйлдвэрийг бүрэн шинэчлэх төсөл хэрэгжээд явж байна. Төсөл 3 үе шаттай явагдаж байгаа бөгөөд төслийн 1-р үе шат бүрэн дууссан, үйлдвэр ажиллаад эхэлсэн. Төслийн 2-р үе шат өнөөдрийн байдлаар 70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд 2026 оны 12 сарын 31-нд бүрэн ашиглалтанд орно. Төслийн 3-р үе шат болох мал төхөөрөх үйлдвэр 2027 оны 12 сарын 31-нд ашиглалтанд орсноор хөрөнгө оруулалтын бүх төсөл 100% гүйцэтгэгдэж дуусна. Хөрөнгө оруулалтыг гадаад болон дотоодын банкны зээлээр гүйцэтгэж байгаа бөгөөд энэ хөрөнгө оруулалтыг бид 5-10 жилийн хугацаанд нөхөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Асуулт 3: Энэ жил Мах Импэкс ХК 80 жилийн ой болж байгаа юм байна. Ахмад настуудад чиглэсэн ямар ажил хийж байна, хүлээн авах уу? –

Хариулт - Компанийн түүхэн 80 жилийн ойн баярыг тохиолдуулан байгууллагынхаа хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан ахмад настууддаа хүндэтгэл үзүүлэх, тэдний гавьяа зүтгэлийг алдаршуулах зорилгоор хүлээн авалтын арга хэмжээг зохион байгуулна. Мөн ахмадууддаа чиглэсэн арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. - Төрийн одон медаль, салбарын шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлон уламжлах - Ахмад настуудаас дурсамж, ярилцлага авч, түүхэн ойн номоо бичих болон олон нийтэд түгээх контент бэлтгэх - Шинээр байгуулагдсан бүтээн байгуулалт, шинэхэн үйлдвэрээ ахмадууддаа танилцуулах, байгууллагын хөгжлийн талаар мэдээлэл өгөх - Ахмад настуудыг хүлээн авч, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж, тэдний оролцоог хангах зэрэг ажлууд байгаа. Уг арга хэмжээ нь байгууллагын үнэт зүйлсийг бэхжүүлэх, үе хоорондын залгамж холбоог хадгалах, ахмад ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийг үнэлэн талархах ач холбогдолтой билээ.

Асуулт 4: Экспортын үйл ажиллагаа хэр явж байна. Ямар ямар улсуудад экспорт хийж байна. Цаашдын зорилт юу байна.

Хариулт: - 2025 онд манай компани БНХАУ-д адууны шулж хөлдөөсөн мах, Иран улсад хонины ангилсан мах, Азарбайджан улсад хонины хөлдүү гулууз мах, хонины сүүл экспортлосон. Цаашид экспортын борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Ойрхи дорнодын улс орнуудад болон Узбекистан улсад халал аргаар бэлтгэсэн хонины мах экспортлох, мөн ОХУ-д мах экспортлох зөвшөөрөл авахаар бэлтгэл ажлууд хийж эхлүүлсэн байгаа.

Асуулт 5: Энэ жил нөөцийн мах их үнэтэй боллоо. Нөөцийн мах олдохгүй байна. Хаагуур яаж зарагдаж байна.

Хариулт: - Энэ жилийн хувьд зах зээл дээрх махны үнэ ханш өндөр олдоц бага байна. Манай компани 926 тн нөөцийн мах бэлтгэсэн. БГД, ЧД, СХД-үүдийн нийт 134 дэлгүүрүүдээр түгээлт, нийлүүлэлтийг тасралтгүй хийж байна.

Асуулт 6 Энэ онд зохион байгуулагдсан малчдыг дэмжих хөтөлбөр цаашид үргэлжлэх үү?

Хариулт: - Бид малчдыг дэмжих хөтөлбөрийг 2019 оноос жил бүр зохион байгуулж байгаа болно. 2025 онд 100 толгой мал тушаасан малчдын дунд сугалаа явуулж, мотоцикл, цахилгаан үүсгүүр зэрэг нийт 40 гаруй сая төгрөгийн азтан тодруулсан болно.

Бид 2026 онд 80 жилийн ойн хүрээнд Малчдын амрах байрыг шинээр тохижуулах, малчдаа хүлээн авах зэрэг ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Асуулт 7: Бүтээн байгуулалт их хийж байна. Хүчин чадал нь хэр вэ?, 2026 оны зорилтыг тодруулмаар байна.

Хариулт: - Мах импэкс компаний үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойг угтан МИК-80 төслийг 2019 оноос эхлэн боловсруулж, хэрэгжүүлж байна. Энэ төсөл гурван үе шаттай 2021-2026 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. I үе шат Боловсруулах үйлдвэрийн төслийг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгч үйл ажиллагаа нь жигдэрсэн. 2, 3 дахь шатны төслүүд технологи болон техникийн хэрэгжилтийн шатандаа явж байна. 2026 ондоо багтааж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Төсөл хэрэгжсэнээр төмөр зам, авто зам, дэд бүтцийн нэгдсэн сүлжээг түшиглэсэн орчин үеийн европ стандартад нийцсэн боловсруулах үйлдвэр, -20°C температурт төрөл бүрийн мах хадгалах 9736 тоннын хүчин чадалтай аммиакан хөргүүртэй агуулах, +2°-+4° температурт нарийн ногоо, өндөг, болон жимс, жимсгэнэ хадгалах 616 тоннын багтаамжтай хөргүүртэй агуулах, мөн Мах ангилан боловсруулах үйлдвэр, ажилчдын нийтийн үйлчилгээний төв, хүнсний нэгдсэн лавлагаа лабораторийн хэсгийг багтаасан 30000 гаруй м2 талбайд баригдах нийт 5-н блок барилга, тэдгээрийн дэд бүтэц болон, тоноглолыг иж бүрэн хийж ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Хурлын дарга Н.Алтан-Эрдэнэ : Цахимаар ирсэн асуултыг багцалж холбогдох удирдах албан тушаалтнууд хариуллаа, өөр санал асуулт байхгүй байна. Та бүхний үнэтэй саналыг бид сонслоо, тэмдэглэлд тусгагдаж байгаа болно, хойшдын ажилдаа мөрдлөг болгоно, та бүгдэд баярлалаа. Одоо түр завсарлая, тооллогын комиссыг ажилдаа орохыг урья гэв.

Үүний дараа тооллогын комиссын дарга Б.Хонгорзул "Саналын хуудсыг тоолж, дүнг танилцуулах тухай" тогтоолыг уншиж танилцуулав./ уг тогтоолыг хурлын материалын..... хуудсанд хавсаргав.

Б.Хонгорзул : Компанийн нийт 3.800.721 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9.982 хувьцаа эзэмшигчдээс хуралд 3.069.891 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа 19 хувьцаа эзэмшигч оролцов.

Тооллогын комиссоос тараасан саналын хуудас 19 ширхэг, хураан авсан саналын хуудас 19 ширхэг, үүнээс асуулга тус бүрээр хүчинтэй саналын хуудас 19 ширхэг, асуулга тус бүрээр хүчингүй саналын хуудас байхгүй байна.

1. Компаний 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлахыг зөвшөөрсөн ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
3. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:
 1. Б.Саруулыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
 2. Б.Намууныг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
 3. Б.Оргилболдыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
 4. Б.Барсболдыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан түдгэлзсэн санал байхгүй.
 5. Х.Цэндбаярыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
 6. Ж.Баттөрийг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.

ТУЗ ийн хараат бус гишүүнээр:

- М.Лхачинбалыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан , түдгэлзсэн санал байхгүй.
- Б.Оргилыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.
- Т.Золбаярыг сонгохыг зөвшөөрсөн 3.069.981 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй.

- 2026 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 12.750.000 төгрөгөөр батлахыг зөвшөөрсөн 3.069.891. ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн санал бахгүй.
- 4. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашиг 100 төгрөгөөр байхаар тогтоосоныг зөвшөөрсөн 3.069.891 ширхэг хувьцаа буюу нийт саналын 100 хувь, татгалзсан, түдгэлзсэн байхгүй гэсэн дүн тоологдсон тул Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ: Дээрх хэлэлцсэн асуудлаар Тогтоол гаргуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай. гэж танилцуулав.

Тооллогын Комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас №01 тоот тогтоол гаргав.

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас ТОГТООХ НЬ :

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг зүйтэй гэж үзсүгэй.
2. Компанийн 2026 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр
 - Х.Цэндбаяр
 - Б.Намуун
 - Б.Саруул
 - Б.Барсболд
 - Б.Оргилболд
 - Ж.Баттөр нарыг

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр :

- Т.Золбаяр
- Б.Оргил
- М.Лхачинбал нарыг компанийн дүрэмд зааснаар 3 жилийн хугацаатай сонгосугай.
- 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг 12.750 төгрөгөөр баталсугай.
- 5. Нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 100 төгрөгөөр тогтоосугай гэж тогтоолыг уншиж танилцуулсанаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ажиллагаа өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА
ТЭМДЭГЛЭСЭН



Н.АЛТАН-ЭРДЭНЭ
И.ӨЛЗИЙБАЯР